

# ДЭД МОДУЛЬ I-1

**ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, НОГООН ХӨГЖИЛ,  
ҮНДСЭН ОЙЛГОЛТ**

**(Өчигдөр, өнөөдөр, маргааш)**



## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, НОГООН ХӨГЖИЛ, ҮНДСЭН ОЙЛГОЛТ (ӨЧИГДӨР, ӨНӨӨДӨР, МАРГААШ)

Сэдвийн хэрэгцээ	<p>Хүн төрөлхтөн үүссэн цагаас өнөөг хүртэлх түүхийг эргэн харвал харилцан адилгүй, онцлогтой хэд хэдэн үе шатыг дамжсан байдаг. Үүнийгээ хөдөө аж ахуйн эрин үе, үйлдвэрлэлийн эрин үе, технологи, мэдлэгийн эрин үе гэх мэтээр нэрлэжээ.</p> <p>Ингэхдээ хөгжлийг салбар тус бүрээр авч үзэн, эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжил гэх мэтээр саланги байдалд өөрчлөлт, шинэчлэлийг хийдэг байсан. Салбар бүрт шинэчлэл хийхдээ бусад салбартай уялдах байдлыг үл харгалзсанаас нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудалд гажиг үүсч, байгаль орчинд сөрөг нөлөөг үзүүлэх болсон. Тухайлбал, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд эдийн засгийг хөгжүүлэхдээ байгаль орчны даац чадавхийг үл харгалзсанаас байгаль ахуйн тэнцвэр алдагдаж, энэ нь хүн төрөлхтний ахуй амьдралд сөрөг нөлөөг үзүүлэх болсон.</p> <p>Тиймээс хүн төрөлхтөн оюун ухаанаа сорьж, хамтаар хэлэлцэн байж, тогтвортой хөгжлийн замыг сонгон, тогтвортой хөгжил, ногоон хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр дэлхий, бүс нутаг, үндэсний хэмжээнд ажиллаж, уриалга, зөвлөмж, шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж байгаагийн нэг нь 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн хурлаас дэвшүүлсэн “ТХБ-ын 17 зорилт” юм.</p> <p>Монгол Улсын хувьд “Эхлээд хөгжье, дараа нь цэвэрлэе” гэсэн өнөөгийн хандлагыг өөрчлөн, байгальд ээлтэй, хаягдал багатай, үр ашигтай үйлдвэрлэлийг хөгжүүлэн, бүтээмжийг дээшлүүлж, нийгмийн оролцоог хангасан, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгон, хүн амын амьдралын чанарыг сайжруулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.</p>
Зорилго	<p>Тогтвортой хөгжил, ногоон хөгжийн үзэл санаа, ач холбогдлыг ухаарч, ТХ/НХ-ийн дэлхийн хөгжлийн явц, цаашдын чиг хандлагын талаар ойлголттой болох.</p>
Суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар	<ul style="list-style-type: none"> <li>✓ Тогтвортой хөгжил, ногоон хөгжил гэсэн ухагдахууны учир утга, үзэл баримтлал, гол санааг ойлгох</li> <li>✓ ТХ/НХ-ийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын утга санааны талаар ерөнхий ойлголттой болох</li> <li>✓ ТХ-ийн үзэл баримтлал, гол санаануудыг тодорхой жишээн дээр суурилан тайлбарлаж чаддаг байх</li> <li>✓ ТХ-ийн үйл явцыг эдийн засаг, нийгмийн хөгжил, экосистемийг хамгаалах болон бодлогын уялдаа холбоонд авч үзсэн загварын учир утгыг тайлбарлах</li> <li>✓ Экологийн ул мөрийн талаар ерөнхий ойлголттой болох, тайлбарлаж чаддаг байх</li> <li>✓ Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого, стратегийн 6 зорилтыг орон нутгийн онцлогийг тусгасан жишээнүүдээр баяжуулан, амьдралд хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах</li> </ul>

Агуулга	Сэдэв	
	Тогтвортой хөгжил ба ногоон хөгжил	<ul style="list-style-type: none"> <li>✓ Экологийн ул мөр</li> <li>✓ Тогтвортой хөгжил</li> <li>✓ Ногоон хөгжил</li> </ul>
	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг таниулан, ойлгуулах дасгал ажлууд	<ul style="list-style-type: none"> <li>✓ Амьдралыг тань өөрчлөж болох 10 асуулт</li> <li>✓ Нийгэм эдийн засаг, байгаль орчны уялдаа холбоо</li> <li>✓ Тогтвортой ирээдүйг урьдчилан төсөөлөх нь</li> <li>✓ Юу чухал болохыг шийдэх</li> </ul>

Сургалтын арга зүй	Төрөл	Нэр	Хэрэглэгдэхүүн
	Мэдээлэл	Экологийн ул мөр	Танилцуулга Гарын авлага Видео
	Мэдээлэл	Тогтвортой хөгжил үндсэн ойлголт	Танилцуулга Гарын авлага Видео
	Мэдээлэл	Ногоон хөгжил	Танилцуулга Гарын авлага Видео
	Дадлага ажил - 1	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг таниулан, ойлгуулах дасгал ажлууд	Дадлага ажлын хуудас
Сургалтын зорилтот бүлэг	Энэхүү сургалтын модулийг бүх нийтийн насан туршийн боловсролыг дэмжих хүрээнд бүхий л оролцогч талууд хэрэглэх боломжтой.		
Сургалтын үнэлгээ:	<ul style="list-style-type: none"> <li>✓ Сургалтад оролцогчдын сэтгэл ханамжийн үнэлгээ</li> <li>✓ Сургалтын явцад гарсан мэдлэг, чадварын ахиц, дэвшил (оношлогоо)</li> <li>✓ Сургалтын эхэнд болон төгсгөлд оролцогчдын мэдлэг, чадварыг тандан, дүн шинжилгээ хийнэ.</li> </ul>		